



ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ УЛС БУС ОРОЛЦОГЧ

10 АНГИД ҮЗСЭН СЭДВЭЭ ДАВТАХ

Олон улсын харилцаа

Олон Улсын харилцааны үндсэн оролцогч

Олон Улсын харилцааны улс бус оролцогч

Иргэн оролцогч

Хөрш улсуудын харилцаа

Олон улсын харилцаа	Олон улсын харилцаа
Мэдсэн зүйл	Мэдэхийг хүсэж буй зүйл

Олон Улсын харилцааны улс оролцогч

Улс оролцогчийг Де-факто, Де-юре хоёр хэлбэрээр хүлээн зөвшөөрдөг. Де-факто гэдэг нь латин үг бөгөөд “бараг хууль ёсны” гэсэн утгатай. Олон улсын эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн бус хүлээн зөвшөөрсөн хэлбэр юм. Энэ хүлээн зөвшөөрөл нь тухайн улсад бүрэн итгэл хүлээлгэхгүй байгаагийн илрэл бөгөөд цаашид бүрэн хэмжээнд хүлээн зөвшөөрөхийн эхлэл байж болно. Тухайлбал, Монгол Улс бүрэн эрхт улсын хувьд олон улсын эрх зүйн хүрээнд де факто улс байх статусыг 1961 он хүртэл эдэлж байв. Де-юре гэдэг нь латинаар хууль ёсны гэсэн утгатай бөгөөд олон улсын эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн хүлээн зөвшөөрөх хэлбэр юм. 1961 онд НҮБ-ын гишүүнээр элссэн нь манай улс олон улсын хэмжээнд бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн бүрэн эрхт улс болж олон улсын харилцааны үндсэн оролцогч болсон юм.

Олон улсын харилцааны “улс” оролцогч

Их гүрэн:

Өөрийн аюулгүй байдлыг төдийгүй хөрш, холбоотон улсууд, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах хүчин чадалтай байдаг.

Дунд улс:

Өөрийн ойрын хүрээлэлдээ ялангуяа хөрш улсууд, бүс нутагтаа баттай нөлөөлдөг, голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсууд байдаг.

Бага улс:

Олон улсын харилцаанд нөлөө багатай ч өөрийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэрэгсэлтэй байдаг.

ТУЛГУУР ОЙЛГОЛТ

Олон улсын харилцаа (ОУХ) — дэлхий олон улсын хоорондох олон талт холбоо харилцааг судалдаг шинжлэх ухаан юм.

Олон Улсын харилцааны үндсэн оролцогч-НҮБ-ийн гишүүн улсууд

Олон Улсын харилцааны улс бус оролцогч –Засгийн газрын оролцоогүйгээр улс,үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагууд.

Олон улсын харилцааны эрх зүй-Олон улын харилцаанд оролцогчдын хоорондын харилцааг зохицуулдаг хууль зүйн зарчим, хэм хэмжээний тогтолцоо юм.

СУРАХ БИЧИГ 169 ХУУДАС УНШИХ

<https://www.etv.mn/?p=10493>

Транспаренси Интернэшл байгууллагын талаар

Транспаренси Интернэшл байгууллагын талаар ойлгосоноо бичих
Авилга

УЛС БУС ОРОЛЦОГЧДЫН АНГИЛАЛ





Үйл ажиллагаа 6.2. Баримтыг шинжлээрэй.

1. Ярилцлагыг уншаад асуултад хариулна уу.

Монгол улсын гадаад бодлогын алтан аргамжааг богиносгож болохгүй

Олон улсын, бүс нутгийн нэгдлүүд тодорхой зорилгын дор байгуулагддаг. Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага (ШХАБ) ямар зорилготой байгуулагдаж, ямар үр дүн гаргаж ирсэн нэгдэл вэ?

ШХАБ анх 1996 онд “Шанхайн Тав” нэртэй байгуулагдахдаа оролцогч орнуудын хил орчимд цэргийн итгэлцлийг гүнзгийрүүлэх, хил орчмын цэргийн хүчний тоог багасгах зорилго тавьсан байдаг. Угтаа бол Исламын хэт даврагсдын өдөөн хатгалгаар ямар нэг үл ойлголцол үүсэж, хил орчимд будилаан, зэвсэгт мөргөлдөөн гарахаас сэргийлэх үүрэгтэй байж. 1997 онд ШХАБ-ын хүрээнд ОХУ, БНХАУ-ын удирдагчид дэлхий “олон туйлт” байх ёстой гэж тунхагласан. Эндээс үзвэл ШХАБ нь дотогшоогоо бол Дундад Азийн орнуудыг Орос, Хятад хоёр талаас нь хашиж, тэндээс терроризмын аюул занал гаргуулахгүй байх, гадагшаага бол АНУ тэргүүтэй барууныг сэргүүлэн ажиллах шинэ туйл бий болгох үүрэг хүлээсэн байгаа юм. Өнгөрсөн хугацаанд ШХАБ нэг хэсэг улсын бүлэглэлээс олон улсын байгууллага болж, гишүүн орны тоо 6-аас 8 болж өргөжсөн, дан цэрэг-аюулгүй байдлын чиглэлтэй байснаа одоо бүх чиглэлийн салбарыг хамарсан зорилготой болсон байна. Байгууллага тэлэх, гадаад харилцаагаа өргөтгөн бэхжүүлэх, гадна талдаа хүлээн зөвшөөрүүлэх тал дээр төвлөрч ажилласнаас биш яг эдийн засгийн үр өгөөжтэй хийсэн ажил юу байгааг мэдэхгүй байна.

Эх сурвалж: www.trends.mn Ахмад дипломатч С. Бадралтай хийсэн ярилцлагаас

Олон улсын байгууллага

Бүтэц зохион байгуулалт

Улс орнуудад илүү
нээлттэй, байгууллагын бүтэцтэй

Гишүүн орнуудын чиглэлээр үйл
ажиллагаа явуулдаг

Зорилго чиглэлийн хувьд

Улс орны хувьд ажилладаг

Үүсгэн байгуулагчийн хувьд

Засгийн газрууд байгуулдаг

Төрийн бус байгууллага

Бүтэц зохион байгуулалт

Иргэн байгууллагад илүү нээлттэй
Сайн дурын шинжтэй

Иргэний нийгмийн чиглэлээр үйл
ажиллагаа явуулдаг


Зорилго чиглэлийн хувьд

Тодорхой чиглэл хүрээнд ажилладаг

Үүсгэн байгуулагчийн хувьд

Хувь хүн, иргэн, байгууллага

Хамгийн өргөн хүрээнд хамтран ажилладаг олон улсын байгууллагууд



“Тогтвортой хөгжил -2030 хөтөлбөр”-ийг анх 2012 онд Рио Де Жанейро хотод НҮБ-ын “Тогтвортой хөгжил” бага хурлын үеэр санаачилсан **“Нийгэм, эдийн засаг, байгаль орчин** гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхийн нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг юм.

2015 онд НҮБ-ын Ерөнхий Асамблейн 70 дугаар чуулган болж, ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1 сарын 1-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн.



ҮЙЛ АЖИЛЛАГАА 6.3 АЖИЛЛАХ 173 ХУУДАС

1. Дараах ойлголтыг тайлбарлана уу.
 - а) Олон улсын байгууллага
 - б) Олон улсын төрийн бус байгууллага
2. “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичгийг уншаад дараах асуултын дагуу ярилцана уу. (<http://www.legalinfo.mn/annex/details/7105?lawid=11725>)
 - а) Монгол улс яагаад энэ баримт бичгийг баталсан бэ?
 - б) Монгол улс тогтвортой хөгжлөө хангах чиглэлээр ямар зорилт тавьсан бэ?
3. Монголд үйл ажиллагаа явуулж буй олон улсын ТББ-ын салбар болох Эмнэсти Интернейшнл байгууллагын үйл ажиллагааны талаар а) мэдээлэл цуглуулаарай б) цуглуулсан мэдээллээ нэгтгэж танилцуулга бэлтгээрэй. (www.amnesty.mn)

Цуглуулах мэдээллийн агуулга:

- Байгууллагын зорилго
- Байгууллагын түүх
- Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, манай улсад зохион байгуулсан гол гол үйл ажиллагаа, түүний үр дүн

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА НЬ ЭРХ ЗҮЙН СУБЪЕКТ БОЛОХ НЬ

- НҮБ-ын Дүрмийн 104-р зүйлд “НҮБ нь өөрийн гишүүн орны нутаг дэвсгэр дээр үүргээ гүйцэтгэх болон зорилгодоо хүрэх шаардлагатай эрх зүйн чадамжийг эдэлнэ” гэжээ.
- Далайн эрх зүйн 1982 оны конвенцид “Олон Улсын Далайн Байгууллага нь олон улсын эрх зүйн субъект мөн бөгөөд өөрийн үүргийг хэрэгжүүлж, зорилгодоо хүрэхэд шаардагдах эрх зүйн чадамжтай байна” гэж заасан байдаг.

Гэхдээ ОУБ нь хязгаарлагдмал хүрээнд, зөвхөн өөрийн үйл ажиллагааны зорилготой холбоотой асуудлаар эрх зүйн чадамж эдэлдэг. Тухайлбал:

**Үйл ажиллагаа явуулж буй орныхоо хууль тогтоомжийн дагуу
хуулийн эрх эдэлнэ
Улс орны дотоод хэрэгт оролцохгүй
Учирсан хохирлынхоо талаар зарга үүсгэх эрхтэй**

ҮЙЛ АЖИЛЛАГАА АЖИЛЛАХ 175 ХУУДАС

№	Онолын чиглэл	Үндсэн үзэл баримтлал
1.	Реалист онол	ОУХ-ны тоглогчид нь зөвхөн үндэсний бүрэн эрхт улсууд байдаг.
2.	Либерал онол	ОУХ-ны үндсэн тоглогч бүрэн эрхт улс дангаар биш түүнээс гадна ОУБ, томоохон компаниуд, үндэсний болон бусад нийгэмлэг, хувь хүмүүс ОУХ-д оролцож байдаг.
3.	Марксист онол	ОУХ-ны үндсэн тоглогчид нь нийгмийн ангиуд байна.
4.	Неомарксист онол	ОУХ нь нийгмийн тодорхой анги бүлэглэлүүдийн харилцааны үр дүн юм.
5.	Неореалист онол	ОУХ-ны тоглогчид нь бүрэн эрхт улс, тэдгээрийн холбоо, эвсэл байна.
6.	Неолиберал онол	ОУХ-ны бүрэн эрхт субъектүүд нь бүрэн эрхт улс, үндэстэн дамнасан корпорацууд, ЗГ-ын бус байгууллагууд, хувь хүмүүс байдаг.

1. Онолын чиглэлүүд нь ОУХ-ны улс бус оролцогчийн талаар ямар байр суурийг баримталж байна вэ?
2. Улс бус оролцогчийн талаарх онолын чиглэлүүдийн хоёр гол ялгааг тодорхойлно уу.
3. Улс бус оролцогчийн талаарх онолын тайлбартай танилцаж, тэднийг ялгааг тодорхойлсноор улс бус оролцогчийн талаар та юу мэдэж авав?
4. Дараах шийдлээр мэтгэлцэнэ үү.

Шийдэл: “Ихэнх улс орон ОУБ-д олон улсын эрх зүйн субъект байх эрх олгохоос татгалздаг. Учир нь ОУБ бүрэн эрхт улсаас илүү их эрх мэдэлтэй, бие даасан болно гэж болгоомжилдог.”

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ТУЛГУУР ЧИГЛЭЛ

- Хөрш орнуудтайг аа найрсагаар тэнцвэртэй харилцах

- Азийн бүс нутгийн улс төр эдийн засгийн интеграцид оролцох


- Өрнө Дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсан харилцаа хөгжүүлэх

- Хөгжиж буй орнуудтай нийтлэг зорилтын үүднээс бодит боломжийн хэмжээнд хамтран ажиллах

- НҮБ болон ОУБ-тай хамтран ажиллах

- Социализмын дараах орнууд, ТУХН-ийн орнуудтай найрсаг харилцаа хөгжүүлэх

МОНГОЛ УЛСЫН ГОЛЛОХ ГАДААД БҮС НУТАГ, УЛС ОРНУУД



МОНГОЛ УЛСЫН ГОЛЛОХ ГАДААД БҮС НУТАГ, УЛС ОРНУУДЫН ТАЙЛБАР

Зүүн Хойд Ази: Монгол улс Солонгосын хойгийн аюулгүй байдлын асуудалд ихээхэн анхаарал тавьж, хоёр Солонгостой найрсаг харилцаатай байхыг эрхэмлэдэг. Гэвч энэ бүс нутагт ашиг сонирхлын зөрөлдөөнтэй олон асуудал байдаг. Тус бүс нутгийн орнууд болох ОХУ, БНХАУ, АНУ, Канад, Япон, БНСУ, БНАСАУ зэрэг улсын бодлогоос бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагаа шууд хамааралтай юм.

Төв ба Евро Ази: Энэ бол ОУХ-нд түүхэн уламжлалтай геополитикийн нөлөө бүхий бүс нутаг бөгөөд ОХУ, Хятадын нөлөө ихтэй. ШХАБ, Евразийн эдийн засгийн холбоо (ЕЭЗХ) зэрэг бүс нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах нь ирээдүйд манай улсад чухал ач холбогдолтой байх болно.

Зүүн ба зүүн өмнөд Ази: Ази, Номхон далайн орнуудын нэг хэсгийг хамарна. Монгол улс 1998 онд АСЕАН-ны улс төр, аюулгүй байдлын асуудлаарх яриа хэлэлцээний үйл явц болох АСЕАН-ны Бүсийн чуулга (АРФ)-д гишүүнээр элсэж, 2005 онд АСЕАН-ны Найрамдал, хамтын ажиллагааны гэрээнд нэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ГОЛЛОХ ГАДААД БҮС НУТАГ, УЛС ОРНУУДЫН ТАЙЛБАР

Улс орнуудын харилцан хамаарал улам бүр гүнзгийрч, аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ орчин бүрэлдэж байгаа өнөөгийн нөхцөлд Монгол улсаас олон улсын хамтын нийгэмлэгийн хүрээнд явуулах бодлого, олон талт дипломат ажиллагааны ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэж байна. Дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд ОУБ-ууд, ялангуяа, НҮБ чухал үүрэгтэй. Иймд Монгол улс НҮБ-ын үйл ажиллагаанд улам бүр идэвх, санаачилгатай оролцож байна. Тухайлбал, Ерөнхий Ассамблейн 63-р чуулганы дэд даргаар (2008-2009), ЮНЕСКО-ийн гүйцэтгэх зөвлөлд гишүүнээр (2007-2011), Олон улсын худалдааны эрх зүйн комиссын гишүүнээр (2004-2010), Олон улсын атомын энергийн агентлагийн захирагчдын зөвлөлийн гишүүнээр (2009-2011) тус тус сонгогдон амжилттай ажилласан юм.

Монгол улс 2011 оны 7-р сараас Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг (АОХН)-ийг 2 жилийн хугацаагаар даргалан ажилласан. Эдүгээ АОХН-ийн удирдах зөвлөлд 25 орон нэгдэж ороод байгаа. Ийнхүү Монгол улс дэлхий нийтийн ба бүс нутгийн олон улсын харилцаанд бие даан оролцогч чухал субъект гэдгээ нотлон харуулсаар байгаа билээ.

ГЭРИЙН ДААЛГАВАР ХУУДАС-175

Сурах бичиг 175 хуудас



Гэртээ хийгээрэй.

1. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ОУХ-ны улс бус оролцогчдын талаар мэдээлэл цуглуулаарай.
2. Цуглуулсан мэдээллээ дараах дарааллын дагуу танилцуулахад бэлтгээрэй.

Үүнд:

- а) Тухайн оролцогчийн үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл
- б) Байгуулагдсан түүх
- в) Монгол улсад явуулж буй үйл ажиллагаа, түүний үр дүн, ач холбогдол



Нэмж судлаарай

- <http://consul.mn/041ubdtg.php>
- <https://immigration.gov.mn/> -зэрэг цахим хуудсыг ашиглаарай.

Сурах бичиг 178 хуудас

Үйл ажиллагаа 6.6 ажиллах